



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 646

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны "Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх тухай" 39 дүгээр тогтоол, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 671,500.00 (зургаан зуун далан нэгэн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын Прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь шүүхийн Тамгын газрын дарга Д.Ганбат, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын Прокурорын газрын Сум дундын Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Ш.Баасандорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0002707

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 онд 12 дугаар сарын 27 ны өдрийн
6/6 дугаар тогтоолын хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГӨ

Д/д	Шилжүүлэх байгууллага	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Өвөрхангай аймгийн	Гадна плитан зам	2006	м.кв	1	240,000.00	240,000.00	-	Өвөрхангай аймгийн
2	Хархорин сум дахь	Навчит мод	1980	ш	41	32,800.00	32,800.00	-	Хархорин сум дахь
3	Шүүхийн Тамгын газар	Шилмүүст мод	1980	ш	3	8,700.00	8,700.00	-	Сум дундын
4		Гадна шороон зам	1976	м.кв	1300	390,000.00	390,000.00	-	прокурорын газар
НИЙТ ДҮН						671,500.00	671,500.00		
						(зургаан зуун далан нэгэн мянга таван зуун)	(зургаан зуун далан нэгэн мянга таван зуун)		